



ГАМШИГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, БРИГАДЫН
ГЕНЕРАЛ Л.БОЛДБААТАР

2026 оны 3 дугаар сарын 19 - ны өдөр



БАТЛАВ
УЛААН ЗАГАЛМАЙ
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Н.БОЛОРМАА

2026 оны 3 дугаар сарын 20 ны өдөр

“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ГАМШГИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХ: АСУУДАЛ, ШИЙДЭЛ” ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

Хугацаа: 2026 оны 5 дугаар сарын 05- ны өдөр
Зохион байгуулагдах газар: Улаанбаатар хот

Зохион байгуулагч:
ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн,
Монголын Улаан Загалмай Нийгэмлэг

Нэг. Үндэслэл

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр гамшгийн давтамж, эрчимтэй нэмэгдэж, улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх болсон. Иймээс дэлхийн улс орнууд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах чиглэлээр хамтын үүрэг хүлээн олон улсын бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улс газарзүйн байршил, эрс тэс уур амьсгал, нүүдлийн мал аж ахуй давамгайлсан эдийн засгийн бүтэц зэргээс шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг орны тоонд ордог.

Иймээс уур амьсгалын өөрчлөлт, түүнтэй уялдсан гамшгийн эрсдэлийн асуудлыг олон салбарын оролцоотойгоор хэлэлцэж, бодит шийдэл, дасан зохицох арга замыг тодорхойлох нь энэхүү бага хурлыг зохион байгуулах үндэслэл болно.

Хоёр. Зорилго

Уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхад тулгамдаж буй асуудлыг онол, практикийн түвшинд тодорхойлж, боломжит шийдлийн хувилбарыг хэлэлцэх, энэ чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршино.

Гурав. Хурлаар хэлэлцэх асуудлуудын ерөнхий чиглэл

1. Уур амьсгалын өөрчлөлтийн шинжлэх ухааны үндэс ба өнөөгийн нөхцөл байдал
2. Байгалийн гамшгийн давтамж, эрчимжилт ба нөлөөлөл
3. Гамшгийн эрсдэлийн удирдлага ба бодлого, төлөвлөлт, эрх зүйн орчин
4. Дасан зохицох ба гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ
5. Гамшгийн эрсдэл даван туулах чадавхыг бэхжүүлэх асуудал
6. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн чадавх ба олон нийтийн оролцоо
7. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн нөлөөлөл
8. Технологи, инновац ба мэдээллийн систем
9. Салбар хоорондын хамтын ажиллагаа ба тогтвортой хөгжил

Дөрөв. Хурлын зохион байгуулалт

Хурлын удирдамжид заасан чиглэлийн хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийдэг эрдэмтэн, судлаач, судлаачдын баг, их, дээд сургуулийн оюутнууд, тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд оролцох боломжтой.

Ирүүлсэн бүтээлийг онол, практикийн бага хуралд хэлэлцүүлэх, эмхэтгэлд хэвлүүлэх гэсэн хэлбэрээр шалгаруулна. Хуралд хэлэлцүүлэх бүтээлийг урьдчилан мэдэгдэх бөгөөд хэлэлцүүлэх илтгэлээ Power point программ дээр хийж 15 минутад багтааж илтгэхээр бэлтгэнэ.

Тав. Өгүүлэлд тавигдах шаардлага

Бүтээлийг А4 хэмжээтэй цаасны 8-12 нүүрэнд багтаан дараах хэлбэрээр бичиж ирүүлнэ.

- Хэрэглээний программ: Microsoft Word
- Үсгийн фонд: Arial
- Бичвэрийн өндөр: 12
- Мөр хоорондын зай: 1.15
- Хуудасны дээд талаас-2 см, доод талаас-2 см, зүүн талаас-3 см, баруун талаас-1.5 см

Өгүүлэл дараах хэсгүүдтэй байна. Үүнд:

1. Өгүүллийн нэр
2. Зохиогчийн овог, нэр, хаяг
3. Хураангуй
4. Түлхүүр үг

5. Оршил
6. Судалгааны материал, арга зүй
7. Судалгааны үр дүн
8. Хэлэлцүүлэг
9. Дүгнэлт
10. Ном зүй

Бүтээлээ эрдэм шинжилгээний өгүүлэл хэлбэрээр 2026 оны 4 дүгээр сарын 10-ны дотор nidr@nema.gov.mn цахим хаягаар болон 51-262539, 94352570 (д/ч У.Ирмүүнзаяа) дугаараар холбогдож ирүүлнэ.

--oOo--